

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТТАЙ ИРГЭДИЙГ ВИЗЭЭС
ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ
АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар /цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэж нэрлэнэ/,

хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэн,

албан ажлаар хоёр улсын хооронд иргэд зорчих явдлыг хөнгөвчлөхөөр шийдвэрлэн,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Хүчин төгөлдөр дипломат, албан паспорт бүхий Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орсон өдрөөс эхлэн 30 хоногоос илүүгүй хугацаагаар байх бол визгүйгээр нэвтэрнэ.

Хоёрдугаар зүйл

Дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт томилогдсон нэгдүгээр зүйлд дурдсан паспорт бүхий хоёр Талын иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд нөгөө Талын нутаг дэвсгэрт визгүйгээр нэвтрэн орох, томилолтын хугацаанд байх, нөгөө Талын визгүйгээр гарахыг зөвшөөрнө.

Гуравдугаар зүйл

1. Хоёрдугаар зүйлд дурдсанаас бусад хүчин төгөлдөр дипломат, албан паспорт бүхий хоёр Талын иргэд 30 хоногоос илүү хугацаагаар нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хүсэлттэй бол урьдчилан виз авч байвал зохино.

2. Дээрх визийг нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газраас хураамжгүйгээр олгоно.

Дөрөвдүгээр зүйл

Дипломат, албан паспорт эзэмшигчид нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа хүлээн авагч орны хууль тогтоомжийг хүндэтгэн сахих үүрэгтэй. Энэ нь тэдний дархан эрх ямбыг хөндөхгүй.

Тавдугаар зүйл

Тааламжгүй гэж үзэж буй иргэнийг Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзаж болно.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үүднээс энэхүү Хэлэлцээрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Ийнхүү

арга хэмжээ авсан тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэнэ. Хэлэлцээрийг сэргээсэн тухайгаа мөн адилаар мэдэгдэнэ.

Долдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс 60 хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Мөн Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцээрийг цуцлах тухайгаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдсэн өдрөөс эхлэн 60 хоногийн дараа хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг 1991 оны аравдугаар сарын 23-ны өдөр Сеул хотноо монгол, солонгос, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд адил хүчинтэй байна.

Тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрх хувийг баримтална.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС**

Гарын үсэг